

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**БАТЛАВ:**  
**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН**  
**ДАРГА** **Б.БАТЦЭЦЭГ**

**ДЭЛХИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖИХ УХААЛАГ ЗАСАГ-2  
ТӨСЛИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ  
ХУДАЛДАЖ АВАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:	Ухаалаг засаг-2 төсөл
Төслийн дугаар:	P176631
Зээлийн дугаар:	7090-MN
Тендер шалгаруулалт / гэрээний нэр:	Төсөл хэрэгжүүлэх нэгжид шаардлагатай тавилга, эд хогшил худалдаж авах

Огноо: 2024 оны 6 сарын 11 өдөр

Улаанбаатар хот  
2024 он

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Захиалагч:** Цахим хөгжил, харилцаа холбооны яам

**Тендер шалгаруулалтын төрөл:** Бараа

**Тендер шалгаруулалтын дугаар:** УЗТ-2/2024020222

**Урилгын дугаар:** УЗТ-2/2024020222

**ХАА-ны мөрдөх журам:** Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журам

**Тендер шалгаруулалтын нэр:** Төсөл хэрэгжүүлэх нэгжид шаардлагатай тавилга, эд хогшил худалдаж авах

Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгжид шаардлагатай тавилга, эд хогшил худалдаж авах ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг тухайн байгууллагын албан тоотоор 2024 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн 15:00 цагаас өмнө [procurement2@smart.gov.mn](mailto:procurement2@smart.gov.mn) цахим шуудангаар ирүүлнэ.

Үнийн саналыг ирүүлэхдээ хавсралтад заасан үйлчилгээ, нийлүүлэлтийн нөхцөлийг хангасан байна.

Үнийн саналыг Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)- ний журмын дагуу үнэлнэ.

Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг уг журмын 3.14. Сонирхлын зөрчил хэсгийг мөрдөнө үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.smart.gov.mn](http://www.smart.gov.mn) хаягуудаас тус тус авна уу.

**Жич:** Танай үнийн санал нь дээр дурдсан үнийн санал эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ёстой.

*Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Самбуугийн гудамж, Сити капитал оффис, 3 давхар, 301 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс*

Утасны дугаар: (976)-51261268

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**  
**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
- 1.1. Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн Зээлдэгчдийн 2020 оны 11 сарын журмыг (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу тендерийн өгөгдлийн хүснэгт (цаашид “ТӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг ТӨХ-д заана.
- 1.2. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 1.3. Банкны Авилгын эсрэг удирдамж, ДБГ-ийн хориг арга хэмжээний хүрээнд батлагдсан хориг арга хэмжээ авах бодлого болон VI хэсэгт ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛД тодорхойлсон журамд заасны дагуу Банкнаас хориг арга хэмжээ авагдсан тендерт оролцогч нь, урьдчилсан шалгуурт тэнцэх эрхгүй, анхлан сонгогдохгүй, үнийн санал болон санал ирүүлэхгүй эсхүл Банкнаас тогтоосон хугацаанд санхүүгийн болон бусад хэлбэрээр Банкнаас санхүүжсэн гэрээг байгуулах, эсвэл Банкнаас санхүүжүүлсэн гэрээний үр шимийг хүртэх эрхгүй. Эрх нь хагадсан компани болон хувь хүмүүсийн жагсаалтыг Банкны вэбсайтаас авах боломжтой. <http://www.worldbank.org/debarr.>”
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
- 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
- (а) Үнийн санал;
  - (б) Бүхий л маягтууд;

- (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
- 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 4.2. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 60 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 6.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 6.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Шалгарсан оролцогч нь шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх

ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Тендер шалгаруулалтын дугаар: GO-RFQ-4.1.1</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем: УЗТ-2/20240202022</p> <p>Захиалагч: Цахим хөгжил, харилцаа холбооны яам</p> <p>Тендер шалгаруулалтын нэр: Төсөл хэрэгжүүлэх нэгжид шаардлагатай тавилга, эд хогшил худалдаж авах</p> <p>Төсөвт өртөг: 41,700,000 /дөчин нэгэн сая долоон зуун мянга/ төгрөг</p> <p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Хуулийн этгээдийн товч танилцуулга</li> <li>3. Үнийн санал /маягтын дагуу ирүүлнэ/.</li> <li>4. Бараа нийлүүлэх хуваарь ирүүлэх.</li> <li>5. Нийлүүлэхээр санал болгосон барааны каталоги ирүүлэх</li> <li>6. Захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолтыг нийлүүлэхээр санал болгож буй барааны харьцуулсан хүснэгтээр ирүүлэх.</li> <li>7. Гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу чанартай, шинэ барааг гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор нийлүүлэх.</li> <li>8. Сүүлийн 2 жилийн (2022,2023 онууд)-ийн аль нэг жилд нь төсөвт өртөгөөс багагүй үнийн дүнтэй, техникийн тодорхойлолтод заасан барааг нийлүүлсэн Гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх. /гэрээний хуулбар, барааг хүлээлгэн өгсөн акт/</li> <li>9. Борлуулалтын хэмжээ: 2022,2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй байх;</li> <li>10. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Төсөвт өртгийн 100 хувьтай дүйцэхүйц дүнтэй байх /харилцагч банкнаас тодорхойлолт гаргаж ирүүлэх/</li> </ol>
<b>ТӨӨЗ 2.3</b>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд хүлээлгэн өгөх баталгааг Бүлэг 4-т тусгагдсан маягтуудын дагуу бөглөж албан бичгээр ирүүлнэ.</li> <li>2. Баталгаат хугацаанд гарсан үйлдвэрийн гэмтлийг өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэхийг нотолсон албан бичиг ирүүлэх.</li> <li>3. Баталгаат хугацаа: 6 сар</li> </ol>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Үнийн санал хүлээн авах хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Самбуугийн гудамж, Сити капитал оффис, 3 давхар, 301 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс</p> <p>Оролцогч нь тендерийг эх хувь-1, хуулбар-1 хувь бэлтгэж ирүүлэх ба хуудас бүрийг дугаарлан материал тус бүрийг битүүмжилж дээрх хаягаар</p>

	<p>ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:  Огноо: 2024 оны 6 дугаар сарын 25 өдөр  Цаг: 15 цаг 00 минут</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Үнийн санал нээх хугацаа нь:  Огноо: 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдөр  Цаг: 15 цаг 30 минут</p>
<b>ТӨӨЗ 4.4</b>	<p>Тендерт оролцогч нь тендер ирүүлэх сүүлийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийн төлбөл зохих бүхий л татвар, хураамж, шимтгэлийг (НӨАТ-аас бусад) тендерийн үнэнд багтаан ирүүлнэ. НӨАТ-ын дүнг ажлын тоо хэмжээний хүснэгтэд тусад нь тэмдэглэж, нийт тендерийн үнийн саналд оруулна.</p>

**ГУРАВДУГААР ХЭСЭГ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Ухаалаг засаг-2 төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжид шаардлагатай тавилга, эд хогшлын техникийн тодорхойлолт**

№	Барааны нэрс	Тоо хэмжээ	Техникийн шаардлага
1	<b>Оффис ширээ</b>	7	Хэмжээ: 1200х600х750мм хэмжээнээс багагүй байх Материал: ДСП буюу сайн чанарын модны үртсэн шахмал хавтантай байх Хөл: Модон шахмал хавтан Шаардлага: Шургуулга, татуургатай байх Өнгө: цайвар завсрын өнгөнүүд санал болгох /Neutral/
2	<b>Оффис сандал</b>	7	Хэмжээ: Өргөн-72-73см Суудлын гүн-50-70 см Өндөр -125-133 см Даац: 125 кг хүртэл Өнгө: Хар Шаардлага: Зөөлөвчтэй, хүний биед харшил өгөхгүй амьсгалдаг материалаар хийгдсэн байх, сайн чанарын дугуйтай байх
3	<b>Босоо шүүгээ (баримт бичиг хийх, хадгалах)</b>	7	Хэмжээ: 185*90*40 см хэмжээнээс багагүй байх Материалын зузаан: 0,9 мм-1.0 см  Материал: Сайн чанарын төмөр эсвэл модон шахмал үртсэн материалтай байх  Шаардлага: 2 шилэн хаалгатай, цоож тулхүүртэй байх, 3-5 давхар тавцантай байх
4	<b>Хурлын ширээ (8 хүний)</b>	1	Хэмжээ: Урт -220-240 см хэмжээнээс багагүй байх Өргөн-120 см Өндөр-75 см Материал: ДСП буюу сайн чанарын модны үртсэн шахмал хавтантай байх
5	<b>Хурлын сандал</b>	10	Хэмжээ: Өргөн-47 см хэмжээнээс багагүй байх Суудлын гүн – 47-50 см Өндөр – 95-100 см Даац-100-125 кг Шаардлага: Гарын түшлэгтэй байх, Зөөлөвчтэй, хүний биед харшил өгөхгүй амьсгалдаг материалаар хийгдсэн байх,
6	<b>Хувцасны шүүгээ</b>	2	Хэмжээ: Доорх заасан хэмжээнээс багагүй байх Өргөн - 106 см Өндөр - 203,5 см, Гүн - 56,5 см Материал: ДСП буюу сайн чанарын модны үртсэн шахмал хавтантай байх Өнгө: Завсрын өнгө/ Царс модны өнгө/, Цагаан өнгө



			Шаардлага: Нэг шургуулгатай, 2 хаалгатай зай талбай сайтай байх. Хувцас өлгөх хөндлөвчтэй, тавиуртай байх
7	<b>Бичиг хэрэг хадгалах шүүгээ</b>	1	Хэмжээ: Өргөн - 80-90 см, Өндөр - 124,5-130 см, Гүн - 42-45 см, Шаардлага: цоожтой 2 хаалгатай, 2 тавиуртай
8	<b>Оффис буйдан</b>	1	Хэмжээ: Урт -187- 214 см Гүн - 84-86 см Буйдан өндөр -74-76 см Суудал - 41-45 см Суудал: 3-4 хүн Материал: Арьсан
9	<b>Цайны ширээ</b>	1	Хэмжээ: Урт -100-120 см хэмжээнээс багагүй байх Өргөн - 60 см Өндөр - 450-480 см Материал: ДСП буюу сайн чанарын модны үртсэн шахмал хавтантай байх
10	<b>Удирдлагын бичиг хэргийн шүүгээ</b>	1	Хэмжээ: 185*90*40 см хэмжээнээс багагүй байх Цоож түлхүүртэй 2 шилэн хаалга, цоож түлхүүртэй, 5 тавиуртай байх
11	<b>Удирдлагын оффис ширээ</b>	1	Хэмжээ: 212*228*74 см хэмжээнээс багагүй байх Материал: ДСП буюу сайн чанарын модны үртсэн шахмал хавтантай байх Хөл: Модон Өнгө: цайвар завсрын өнгөнүүд санал болгох /Neutral/
12	<b>Удирдлагын сандал</b>	1	Хэмжээ: Өргөн-72-73см Суудлын гүн-50-70см Өндөр-125-133 см Даац:125 кг хүртэл Өнгө: хар Шаардлага: Зөөлөвчтэй, хүний биед харшил өгөхгүй амьсгалдаг материалаар хийгдсэн байх, сайн чанарын дугуйтай байх

# ДӨРӨВ ДҮГЭЭР ХЭСЭГ ҮНИЙН САНАЛЫН МАЯГТУУД

Маягт: №1

## НИЙЛҮҮЛЭГЧИЙН ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

Хэнээс:	[нийлүүлэгчийн нэрийг оруулах]
Нийлүүлэгчийг төлөөлөгч:	[нийлүүлэгчийн төлөөлөгчийн нэрийг оруулах]
Албан тушаал:	[төлөөлөгчийн албан тушаал]
Хаяг:	[нийлүүлэгчийн хаяг]
И-мейл хаяг:	[нийлүүлэгчийн и-мейл хаяг]

Хэнд:	[худалдан авагч талын нэр]
Захиалагчийн төлөөлөгч:	[худалдан авагч талын төлөөлөгчийн нэрийг оруулах]
Албан тушаал:	[төлөөлөгчийн албан тушаал]
Хаяг:	[худалдан авагч талын хаяг, цахим шуудан]
Тендерийн дугаар:	[Үнийн саналын урилгын дугаар]
Үнийн саналын огноо:	

*Хүндэт ..... танаа*

### Үнийн санал ирүүлэх

#### 1. Тохиролцол ба Тайлбаргүй

Дээр дурдсан Үнийн санал ирүүлэх хүсэлтийн хариуд бид энэхүү үнийн саналыг Үнийн санал ирүүлэх тухай урилгад дурдсан ажлыг үр дүн, бараа нийлүүлэх гүйцэтгэлийн хуваарь, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэхийг санал болгож байна. Гэрээ болон Үнийн санал ирүүлэх хүсэлтийг хянаж үзээд ямар нэгэн тайлбар шаардлагагүй гэдгээ бид баталж байна.

#### 2. Эрх бүхий этгээд

Үнийн санал ирүүлэх урилгын дагуу бид эрх бүхий этгээдийн шаардлагыг хангаж байгаа бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж байна.

#### 3. Түдгэлзүүлэлт ба хориглолт

Манай байгууллага болон гэрээний аль нэг хэсэгт хамаарч байгаа бусад туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь Дэлхийн банк болон бусад хөгжлийн банкуудын хооронд байгуулсан Хориглох шийдвэрийг харилцан биелүүлэх тухай гэрээний дагуу Дэлхийн банкны группээс түр хугацаагаар түдгэлзүүлэх эсвэл хориглосон аливаа аж ахуйн нэгж, хувь хүнээс хамааралгүй бас хяналтад байдаггүй. Цаашилбал, бид Ажил олгогчийн улс орны хууль тогтоомж эсвэл албан ёсны журмын дагуу эсвэл НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу эрхгүй бус болно.

#### 4. Үнийн санал

4.1 Тендерт оролцогч нь тендер ирүүлэх сүүлийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой НӨАТ-аас бусад бүх татвар, хураамж, шимтгэлийг тендерийн үнэнд багтаан ирүүлнэ. НӨАТ-ын дүнг ажлын тоо хэмжээний хүснэгтэд тусад нь тэмдэглэж, нийт тендерийн үнэнд НӨАТ-ыг оруулна.

4.2 Бидний санал болгож буй үнийн нийт дүн нь [тоогоор болон үсгээр бичнэ үү].

#### 5. Үнийн саналын хүчинтэй хугацаа

Бидний үнийн санал нь Үнийн санал ирүүлэх тухай тендерийн баритм бичигт заасан огноо хүртэл хүчинтэй байх бөгөөд энэ нь бидний хувьд заавал биелүүлэх ёстой бөгөөд хугацаа нь дуусахаас өмнө хэдийд ч хүлээн авч болно.

#### 6. Гүйцэтгэлийн баталгаа

Хэрэв гэрээг бидэнд олговол бид үнийн санал ирүүлэх хүсэлтэд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаагаар хангах үүрэгтэй.

#### 7. Шимтгэл, урамшуулал, төлбөр хураамж

Бид энэхүү Үнийн саналтай холбогдуулан дараах шимтгэл, тэтгэмж, төлбөрийг төлсөн эсвэл төлөх болно

[Хэрэв төлөөгүй эсвэл төлөх ёстой бол “үгүй” гэж заана уу.]

Хүлээн авагчийн нэр	Хаяг	Шалтгаан	Дүн

#### 8. Хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээгээгүй

Бид таныг доорх эрхтэй гэдгийг ойлгож байна:

- a. аливаа үнийн саналыг хүлээн авахаас татгалзах эсвэл хүлээн авах, хамгийн бага үнэлгээтэй үнийн саналыг хүлээн авах үүрэг хүлээгээгүй, эсвэл таны авах боломжтой бусад үнийн саналыг хүлээн авах үүрэг хүлээгээгүй
- b. Гэрээ байгуулах эрх олгохоос өмнөх аль ч үед гүйцэтгэгчид аливаа хариуцлага учруулахгүй цуцлах

#### 9. Залилан ба авилга

Бидний өмнөөс болон бидний нэрийн өмнөөс ажиллаж байгаа ямар ч хүн залилан, авлигын гэмт хэрэгт оролцохгүй байх арга хэмжээ авснаа үүгээр баталгаажуулж байна.

Нийлүүлэгчийн/Гэрээлэгчийн нэрийн өмнөөс:

Нийлүүлэгчийн нэрийн өмнөөс үнийн саналд гарын үсэг зурах эрх бүхий хүний нэр: [үнийн саналд зохих ёсоор гарын үсэг зурах эрх бүхий хүний овог нэрийг оруулна уу] \*

Үнийн саналд гарын үсэг зурж буй албан тушаал хүний нэр: [үнийн саналд гарын үсэг зурж буй хүний бүтэн нэрийг оруулна уу]

Дээр нэр дурдсан хүний гарын үсэг: [нэр, чадавхийг дээр харуулсан хүний гарын үсэг оруулна уу]

Гарын үсэг зурсан огноо [гарын үсэг зурах огноог оруулах] [сар оруулах] өдөр, [оруулах жил]

\* Итгэмжлэлийг үнийн саналд хавсаргана.

**ҮНИЙН ХУВААРЬ**

[Нийлүүлэгч үнийн саналаа ирүүлэхдээ дараахь хэлбэрийг ашиглаж болно. Маягтуудыг аливаа хэлэлцээний дараа гэрээнд ашиглаж болно.]

**Барааны үнийн санал: Үнийн хуваарь 1**  
**Барааг Худалдан авагч улсын гаднаас нийлүүлэх зорилгоор**

1	2	3	4	5	6	7	8	9
Line Item N°	Description of Goods	Эх гарал үүслийн улс	Инкотермсийн тодорхойлсны дагуу бараа хүргэх огноо	Тоо хэмжээ болон эд анги	INCOTERMS 2020, DDP [нэр заасан газарт хүргэх]	DDP нийт үнэ (Col. 5x6)	[DDP Хэрэв нөхцөлөөр шаардсан бол] Худалдан авагчийн улсад бараа бүтээгдэхүүнийг үнийн саналд заасан эцсийн чиглэлд хүргэхэд шаардлагатай дотоод тээврийн болон бусад үйлчилгээний үнэ	Нийт үнэ (Col. 7+8)
[insert number of the item]	[Барааны нэр]	[Гарал үүслийн улс]	[insert quoted Delivery Date quoted phased Delivery periods if applicable] Бараа хүргэх хугацаа оруулна уу	[Тоо ширхэг эд ангийг оруулна уу]	[нэгж DDP үнийг оруулна уу]	[эд ангийг болгоны нийт CIF үнийг оруулна уу]	[нэгж бүрийн тохирох шнийг оруулна уу]	[нийт шнийг оруулна уу]
							Үнийн санал:	



**Үнийн саналд ирүүлсэн бараатай холбоотой үйлчилгээ: Үнийн хуваарь-3**

**Маягт № 2-3**

1	2	3	4	5	6	7	
Item No.	Барааны нэр	Үйлчилгээний тодорхойлолт (барааг эцсийн зогсоол руу хүргэхэд Худалдан авагчийн улсад шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээг оруулаагүй болно)	Country of Origin Гарал үүслийн улс	Дуусах хугацаа Эцсийн очих газарт Completion Period at place of Final destination	Тоо хэмжээ биет нэгж Quantity and physical unit	Нэгж үнэ Unit price	Үйлчилгээ бүрийн нийт үнэ (Col. 5*6 or estimate)
<i>[дугаар]</i>		<i>[Үйлчилгээний нэрийг оруулна уу]</i>	<i>[үйлчилгээ үзүүлэх улсыг оруулна уу]</i>	<i>[insert Delivery Period at place of final destination per Service Үйлчилгээ бүрийн суулийн байршил дах бараа хүргэх хугацаа]</i>	<i>[нийлүүлэх зүйлийн тоо хэмжээ, нэгж бүрийн нэрийг оруулна уу insert number of items to be supplied and name of the physical unit]</i>	<i>[нэгжийн үнийг оруулна уу insert unit price per item]</i>	<i>[нийт үнийг оруулна уу insert total price per item]</i>
Үнийн санал:							

**НИЙТ ҮНИЙН САНАЛ: Үнийн хуваарь 4**

**Бараа нийлүүлэх, хүргэх болон түүний үйлчилгээтэй холбоотой үнийн саналыг доорх байдлаар ирүүлнэ:**

Үнийн хуваарь	Дүн:
Барааны : Үнийн хуваарь 1	
Барааны : Үнийн хуваарь 2	
Үйлчилгээтэй холбоотой: Үнийн хуваарь 3	
<b>НИЙТ ДҮН:</b>	

**Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө ].*

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
<i>[Дугаар бичих]</i>	<i>[Барааны товч тодорхойлолтыг бичих]</i>	<i>[нэгжийн тоо ширхэгийг бичих]</i>	<i>[Хэмжих нэгжийг бичих]</i>	<i>ТХН-ийн оффис</i>	<i>14</i>	<i>21</i>	<i>[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]</i>

**Холбогдох үйлчилгээний жагсаалт ба дуусгах хуваарь**

*[Энэ хүснэгтийг захиалагч бөглөнө. Дуусгах шаардлагатай огноо нь бодитой бөгөөд шаардлагатай бараа хүргэх огноотой нийцэж байх ёстой]*

1	2	3	4	5	6
Үйлчилгээ	Үйлчилгээний тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээ үзүүлэх газар, ажлын талбай	Үйлчилгээ дуусах огноо



**Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага**

Төндөрт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

1.	Гэрээний дугаар	
	Гэрээний нэр	
	Улсын нэр	
2.	Захиалагчийн нэр	
3.	Захиалагчийн хаяг	
4.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
5.	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
6.	Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна) Мөнгөний нэгж                      Мөнгөний нэгж                      Мөнгөний нэгж	
7.	Гэрээний дүн: _____;    Туслан гүйцэтгэх гэрээ: _____;    Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _____;	
8.	Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо	
9.	Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах)	
10.	Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах)	
11.	Техникийн тусгай шаардлагууд.	
12.	Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах.	

**Үйлдвэрлэгчийн итгэмжлэл**

*[Нийлүүлэгч нь үйлдвэрлэгчээс энэ маягтыг заасан зааврын дагуу бөглөхийг шаардана. Энэхүү итгэмжлэлийн бичиг нь Үйлдвэрлэгчийн хэвлэмэл хуудас дээр байх ёстой бөгөөд Үйлдвэрлэгчид заавал дагаж мөрдөх баримт бичигт гарын үсэг зурах эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байх ёстой.]*

Огноо: *[үнийн санал ирүүлсэн огноог (өдөр, сар, жилээр) оруулна уу]*  
ҮСИХ урилгын №.: *[ҮСИХийн дугаарыг оруулна уу]*

Хэнд: *[Худалдан авагчийн бүтэн нэрийг оруулна уу]*

**ХААНА**

*[Үйлдвэрлэгчийн үйлдвэрүүдийн бүрэн хаяг]-т үйлдвэртэй [үйлдвэрлэсэн барааны төрөл оруулна] -ийн албан ёсны үйлдвэрлэгчид болох [Үйлдвэрлэгчийн бүтэн нэр] бид манай үйлдвэрлэсэн дараах [барааны нэр, эсвэл товч тайлбарыг оруулна], барааг нийлүүлэх зорилготой үнийн санал хүргүүлэх итгэмжлэлийг [нийлүүлэгчийн бүтэн нэрийг оруулна уу]-д олгон улмаар хэлэлцээр хийж, гэрээнд гарын үсэг зурхыг зөвшөөрч байна.*

*Дээрх компанийн санал болгож буй барааны талаар бид гэрээний нөхцлийн 20-р зүйлд заасны дагуу бүрэн баталгаа болон баталгаат хугацааг олгох болно.*

*Бид (i) Гэрээний нөхцлийн 27-р зүйлд заасны дагуу албадан хөдөлмөр буюу хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдсон, эсвэл (ii) хүүхдээр хөдөлмөр эрхлүүлдэггүй, ажиллуулдаггүй гэдгээ баталж байна. Түүнчлэн гэрээний нөхцлийн 29-р зүйлд заасны дагуу эрүүл ахуй, аюулгүй байдлын холбогдох үүргээ биелүүлж байгаагаа баталгаажуулж байна.*

Гарын үсэг зурсан: *[Үйлдвэрлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг (гарын үсэг) оруулах]*

Нэр: *[Үйлдвэрлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүтэн нэрийг оруулах]*

Албан тушаал: *[албан тушаал]*

Огноо: он/сар/өдөр *[гарын үсэг зурсан огноог оруулна уу]*

## ТАВДУГААР БҮЛЭГ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.   |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Барааны нийлүүлэлт ба баримт бичиг ирүүлэх</b>      | 4.1 Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ.<br>4.2 Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ. Гэрээнд хэрэглэсэн <b>DDP</b> болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт журмаар зохицуулна. |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>6 сар</b> байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шуурхай хийнэ.   |

- |   |   |
|---|---|
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                 | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                      | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b> | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                   | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>12. Хяналт шалгалт ба аудит</b>                | 12.1. Банкны хяналт шалгалт ба аудит<br>Гэрээний ерөнхий нөхцөлийн хавсралт А “Авилга, залилан мэхлэх үйлдэл”-ийн 2.2 (е) заалтын дагуу, түүний туслан гүйцэтгэгч нь гэрээний гүйцэтгэл, сонгон шалгаруулалтын санал гардуулахтай холбогдуулан ний данс тооцоо, бүртгэлийг банк эсвэл банкнаас томилсон хүнээр шалгуулахыг зөвшөөрөх ба банк шаардлагатай гэж үзсэн үед банкны санал болгосон аудиторoor эдгээр данс тооцоо, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэхийг зөвшөөрнө. Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэх зөвлөх нь дээрх дэд заалтад тусгагдсан банкны хяналт шалгалт, хөндлөнгийн аудиторын эрх үүргийг биелүүлэхэд нь ноцтой саад тотгор учруулсан үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гэрээт ажлыг цуцална.(банкны хориг тавих дүрэм журмын дагуу оролцогчдын эрхийг хасах). |

### **13. Залилан ба авлигын үйлдэл**

13.1. Банк нь Банкны Авилгын эсрэг удирдамж, ДБ-ын Хоригийн арга хэмжээний хүрээнд батлагдсан гэрээний ерөнхий нөхцөлийн Хавсралт А-д заасан хориг арга хэмжээ авах бодлого, журмыг дагаж мөрдөхийг шаарддаг.

13.2. Хэрэв Нийлүүлэгчийн аль нэг ажилтан, албан хаагч Гэрээт ажлын гүйцэтгэлийн явцад авлига, хээл хахууль, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, айлган сүрдүүлэх, саад тотгор учруулах ажиллагаанд оролцсон болохыг Захиалагч, Төслийн менежер эсвэл Нийлүүлэгч олж тодорхойлсон бол Гэрээний Ерөнхий нөхцөлийн хавсралт А-д дагуу тухайн ажилтан, албан хаагчийг ажлаас нь хална.

13.3. Нийлүүлэгч нь түүний туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэх зөвлөхийг Ажилтай холбогдолтой данс тооцоо, бүртгэлийг үнэн зөв, системчлэгдсэн хэлбэрээр хөтлөхийг шаардах бөгөөд ийнхүү хөтлөгдөх данс бүртгэл, тооцоонд цаг хугацааны өөрчлөлт, өртөг зардлыг тодорхой, дэлгэрэнгүй тусгасан байна.

13.4. Нийлүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч/туслан гүйцэтгэх зөвлөх нь гэрээний гүйцэтгэл, сонгон шалгаруулалтын санал гардуулахтай холбогдуулан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн барилгын талбай, данс тооцоо, бүртгэлийг банк эсвэл банкнаас томилсон хүнээр шалгуулахыг зөвшөөрөх ба банк шаардлагатай гэж үзсэн үед банкны санал болгосон аудиторроор эдгээр данс тооцоо, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэхийг зөвшөөрнө. Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэх зөвлөх нь дээрх дэд заалтад тусгагдсан банкны хяналт шалгалт, хөндлөнгийн аудиторын эрх үүргийг биелүүлэхэд нь ноцтой саад тотгор учруулсан үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гэрээт ажлыг цуцлах (банкны хориг тавих дүрэм журмын дагуу оролцогчдын эрхийг хасах) тухай дэд заалтад анхаарлаа хандуулна.

13.5. Захиалагч Нийлүүлэгчээс сонгон шалгаруулалтын үйл явц эсвэл гэрээний гүйцэтгэлтэй холбогдуулан аливаа төлөөлөгч эсвэл бусад талуудад төлсөн эсвэл төлөхөөр зэхэж буй төлбөр хураамж, шан харамжийн талаар мэдээлэхийг шаардах эрхтэй. Захиалагчид өгөх мэдээлэлд наанадаж төлөөлөгч болон бусад талын нэр, хаяг болон мөнгөн дүн, түүний дэвсгэр болон төлбөр хураамж, шан харамж өгөх болсон учир шалтгааныг дурдсан байна. Талуудын аль нэг нь гэрээг ноцтойгоор зөрчвөл Захиалагч эсвэл Нийлүүлэгч тал гэрээг цуцалж болно. Гэрээний ноцтой зөрчилд дараах зүйлс хамаарна. Гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: Хэрэв Нийлүүлэгч нь Захиалагчийн үзэж буйгаар гэрээт ажлын төлөө өрсөлдөх эсвэл гүйцэтгэх үед авилга, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, айлган сүрдүүлэх болон саад тээг учруулах үйл ажиллагаанд оролцсон бол Захиалагч Нийлүүлэгчид бичгээр мэдэгдэл өгснөөс арван дөрөв (14) хоногийн дараа гэрээг цуцалж болно.

# ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ “ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ”-ИЙН ХАВСРАЛТ А

## Авлига, залилан мэхлэх үйлдэл

(Энэхүү хавсралтад заасныг гэрээний нөхцөлд өөрчлөхгүйгээр тусгана)

### 1. Зорилго

1.1 Дэлхийн банк (цаашид Банк гэх)-ны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт бүхий худалдан авах ажиллагаанд Дэлхийн банкны Авлигатай тэмцэх журам болон энэхүү хавсралтыг мөрдөнө.

### 2. Шаардлага

2.1 Банк нь зээлдэгч (Банкны санхүүжилтээс үр шим хүртэгчдийг оролцуулан); тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч болон нийлүүлэгч; аливаа туслан гүйцэтгэгч, дэд зөвлөхүүд, үйлчилгээ үзүүлэгч эсхүл нийлүүлэгч, аливаа төлөөлөгч этгээд (мэдүүлсэн эсэхээс хамааран); тэдгээрийн аливаа мэргэжилтнийг Банкны санхүүжилт бүхий гэрээний худалдан авах ажиллагааны туршид сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр стандартыг ханган ажиллах, залилан мэхлэх, авлигын үйлдлээс ангид байхыг шаардана.

2.2 Энэ хүрээнд Банк нь:

(а) Дараах нэр томъёог дор өгөгдсөн утгаар тусгасан болно. Үүнд:

- i. “Авлигын үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бус хэлбэрээр өгөхийг санал болгох, өгөх, хүлээн авах, өгөхийг шаардахыг хэлнэ;
- ii. “Залилан мэхлэх үйлдэл” гэж аль нэг тал хүлээсэн үүргээсээ зайлсхийх эсхүл санхүүгийн болон бусад ашиг олохын тулд санаатай болон санаандгүйгээр төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийгээд дээрх зорилгоор хийгдсэн зөрүүтэй тайлбарыг хэлнэ;
- iii. “Үгсэн хуйвалдах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг байдлаар хууль бус зорилгод хүрэхийн тулд хоёр буюу түүнээс дээш талууд хамтран далд тохиролцох ажиллагааг хэлнэ;
- iv. “Тулган шаардах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, эсхүл хэн нэгэн этгээд эсхүл түүний өмчид шууд болон шууд бусаар хохирол учруулах, хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ.
- v. “Саад учруулах үйлдэл” гэж

(а) Хяналт шалгалтын нотолгооны материалыг зориудаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуун дарагдуулах, эсхүл авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, албадан шахах буюу тулган шаардах үйлдлийг тогтоохоор Банкнаас хэрэгжүүлж буй хянан шалгах ажиллагаанд зориудаар саад учруулах зорилгоор асуудлыг шалгаж байгаа мөрдөгчид худал мэдүүлэх; эсхүл тухайн хянан шалгах ажиллагаатай холбогдох мэдээллийг мэдэж буй хүн өөрийг нь илчлэхээс сэргийлж айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, мөн шалгалтын дараа гарсан шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзах зэрэг үйлдэл,

(б) Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журмын Хавсралт 4-ийн 2.2 е-д заасны дагуу

Банкны зүгээс хянан шалгах болон аудитын эрхээ хэрэгжүүлэхэд нь ноцтой саад учруулахаар завдах үйлдлийг хэлнэ.

(b) Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсон зөвлөх хуулийн этгээд эсхүл хувь хүн, түүний аливаа ажилтан, төлөөлөгч байгууллага, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн ажилтнууд нь уг гэрээг авах зорилгоор өрсөлдөхдөө авлига, залилан мэхлэх, нууц үгсэн хуйвалдах, албадан шахах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэлд шууд болон шууд бусаар оролцсоныг Банк илрүүлсэн бол уг гэрээ байгуулах эрхийг цуцална;

(c) Холбогдох зээлийн гэрээнд заасан зөрчил арилгах арга хэмжээнээс гадна хэрэв Зээлдэгчийн төлөөлөл эсхүл зээлийн тодорхой хэсгээс хүртэгч этгээд нь тухайн гэрээний худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн явцад авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, тулган шаардах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэл гаргасныг Банк олж тогтоосон бөгөөд энэ үед Зээлдэгчийн зүгээс эдгээр зөрчил бүхий үйлдлийн талаар мэдсэн даруйдаа Банканд мэдээлээгүй, мөн Банкны шаардлагад нийцэхүйц байдлаар цаг алдалгүй засаж залруулахаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд уг худалдан авах ажиллагааг амжилтгүй гэж зарлан цуцалж болно;

(d) Банкны Авлигатай тэмцэх журмыг баримтлан, Банкнаас авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээний талаарх бодлого, журамд заасны дагуу хуулийн этгээд эсхүл хувь хүнийг тухайн заасан хугацааны туршид (i) Банкны санхүүжилт бүхий гэрээ хэрэгжүүлэх эрх авах эсхүл санхүүгийн болон бусад хэлбэрээр ашиг шим хүртэх<sup>1</sup>; (ii) Банкны санхүүжилт бүхий гэрээ байгуулах эрх авсан эрх бүхий хуулийн этгээдийн туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр ажиллахаар нэр нь дэвших<sup>2</sup>; (iii) Банкны зээлийн аливаа хөрөнгөөс хүлээн авах эсхүл Банкны санхүүжилт бүхий төслийн бэлтгэл болон хэрэгжүүлэх шатанд оролцохыг нь хориглон, эрх бүхий бус этгээд гэж нийтэд зарлан мэдээлж болно;

(e) Банкны зээлийн санхүүжилт бүхий гэрээний болон тендерийн/санал авах баримт бичигт (i) тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч, дэд зөвлөх, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон төлөөлөгч этгээдийн хувьд бүх данс, бүртгэл тооцоо, тендер ирүүлэх болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад бичиг баримтад Банкнаас хяналт шалгалт хийх<sup>3</sup>, мөн эдгээр мэдээллийг Банкнаас томилсон аудитораар хянуулахыг зөвшөөрөх тухай заалтыг тусгасан байхыг шаардана.

## **ДОЛОО ДУГААР БҮЛЭГ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

---

<sup>1</sup> Эргэлзээ үүсгэхгүйн үүднээс хориг арга хэмжээ авагдсан талын гэрээ хэрэгжүүлэх эрх бүхий бус байдалд (i) урьдчилсан сонголтод оролцох, зөвлөх үйлчилгээнд сонирхлоо илэрхийлэх, тендер шалгаруулалтад шууд оролцох болон тухайн гэрээний хувьд туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвших, мөн (ii) одоо хэрэгжиж буй гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүрээнд орж ажиллахыг хориглох нөхцөл хамаарах ба мөн үүгээр үл хязгаарлагдана.

<sup>2</sup> Туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвшсэн этгээд (тухайн тендерийн баримт бичгийн төрлөөс хамааран ялгаатай нэрлэдэг) гэдэгт (i) тендерт оролцогчийн хувьд урьдчилсан сонголт эсхүл тендер шалгаруулалтад оролцоход нь шаардагдах чадварын шаардлагыг хангахад дэмжлэг болох чухал ач холбогдол бүхий онцгой туршлагатай, ноу хауг эзэмшсэн этгээд байх; эсхүл (ii) зээлдэгчийн томилсон этгээд байна.

- 1. Шалгах болон турших** 1.1.Барааг хүлээн авах комисс шалгаж , туршиж актаар хүлээн авна.  
1.2.Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:  
1) Баталгаат засварын гэрчилгээ;  
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар** 3.1 Баталгаат засварын тусгай шаардлага.  
Баталгаат хугацаа 6 сараас багагүй
- 4. Төлбөр** 4.1 Захиалагчийн томилсон төлөөлөгч нийлүүлэгчтэй хийсэн бараа хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн акт үйлдсний дараа барааг бүрэн хүлээлгэж өгснөөс хойш 30 хоногийн дотор 100 хувь төлбөр төлнө.
- 5. Алданги оногдуулах**<sup>4</sup> 5.1 Алданги оногдуулах хувь: Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутам 0,01 хувийн алданги тооцно.  
5.2 Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.
- 6. Үнэ** Холбогдох бүх татвар, хураамж багтсан үнэ (НӨАТ-аас бусад): ..... төгрөг  
НӨАТ-ын дүн: .....төгрөг  
Нийт дүн (НӨАТ багтсан) үнэ: .....төгрөг

<sup>4</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.



## ЖИШИГ ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>5</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

<sup>5</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>6</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

<sup>6</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ  
(БАНКНЫ БАТАЛГАА)

*[Захиалагч байгууллагын нэр]*

*[Гүйцэтгэгчийн нэр]* нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь *[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]* (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

*[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс *[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]* –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг *[захиалагчийн нэр]*(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан *[баталгааны дүн тоогоор, төгрөг]/[дүн үсгээр, төгрөг]*-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний баримт бичигт оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноо оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг: